

ГААЛИЙН ТАРИФ, ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Хэлэлцээрийн 3 дугаар хавсралт буюу Гарал үүслийн мэдүүлгийн 21.1-д “гарал үүслийн мэдүүлгийг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч таван мянга (5000)-н еврогоос, эсхүл импортлогч Талын мөнгөн тэмдэгтэд хөрвүүлснээр түүнтэй тэнцэх мөнгөн дүнгээс ихгүй гаалийн үнэ бүхий зохих гарал үүсэлтэй барааны ачилтын хувьд үйлдэж болно”, 21.2-т “Гарал үүслийн мэдүүлэг гэдэг нь үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч тухайн бараатай холбоотой арилжааны (худалдааны) аливаа нэг бичиг баримтад барааны гарал үүслийн талаар бичсэн мэдүүлэг юм. Гарал үүслийн мэдүүлгийг англи хэл дээр машинаар бичиж, тамга дарж, хэвлэх замаар үйлдэнэ” гэж заасан. Өөрөөр хэлбэл, таван мянга (5000)-н еврогоос бага үнийн дүн бүхий барааны гарал үүслийн мэдүүлгийг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч өөрөө гаргах боломжтой болсон.

Гаалийн тариф, татварын тухай хуулийн 31.7.1-д барааны гарал үүслийг нотлох баримт бичгийн хэлбэрийг тодорхойлсон ба зөвхөн барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичгийг хамруулахаар заасан. Иймд гарал үүслийн мэдүүлгийг олон улсын хэлэлцээрт заасан тохиолдолд үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч өөрөө гаргаж болох талаар Гаалийн тариф, татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Мөн тус хуулийн 4.7-д барааны гарал үүслийг нотлох баримт бичгийг 45 хоногийн дотор нөхөн гаргаж өгсөн бол хөнгөлөлттэй тариф хэрэглэх бөгөөд энэ тохиолдолд илүү төлсөн татварыг гаалийн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буцаан олгохоор заасан. Энэ нь Хэлэлцээрийн 3 дугаар хавсралт буюу Гарал үүслийн мэдүүлгийн 24.3-т илүү төлсөн гаалийн татвар, эсхүл депозитоо гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр (12) сарын дотор буцаан авч болох тухай заасан зохицуулалттай хугацааны хувьд нийцэхгүй байна. Иймд олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй тохиолдолд гэсэн агуулгыг мөн хуулийн төслийн зохицуулалтад нэмж тусгасан болно.